



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар

А/43

Хөхбүрд

Орон нутгийн хөгжлийн сангийн  
санал эрэмбэлэх ажлын хэсгийг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.3.4, 4.3.7, 4.4, 4.5, 4.6, 5.6 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хийгдэх ажлын саналыг эрэмбэлэх, төсөл боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:М.Жавзансүрэн (Тамгын газрын дарга)

Гишүүд:Д.Отгонцэцэг (Санхүүгийн албаны дарга)

Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

М.Ганбаатар (Байгаль хамгаалагч)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Д.Батжаргал (Иргэний төлөөлөл)

Т.Цэцэгсайхан (Иргэний төлөөлөл)

2.Төлөвлөгөө гарган ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилтийг Удирдлагын багт танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Жавзансүрэн)-д хариуцуулсугай.

3.Эрэмбэлэгдсэн санал, төсөл арга хэмжээ бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг маягт журмын дагуу бэлтгэн, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БЯМБАДОРЖ

642401293

